



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Бүгд найрамдах нам (БНН)-ын
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Бүгд найрамдах нам (БНН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Г.Банзрагчийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Бүгд найрамдах намын дарга Б.Жаргалсайханаас “Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн 2019 оны дүрэм 6 бүлэг, 27 зүйл, 228 заалттай байсныг шинэчилж 8 бүлэг, 30 зүйл, 272 заалттай болгон өөрчилсөн тул бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг 76 хуудас баримт, 1 ширхэг флашны хамт 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба тухайн ажиллагааны явцад нэмэлтээр ирүүлсэн 56 хуудас баримтыг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Бүгд найрамдах нам нь хуульд заасан хугацааны дотор өөрийн намын дүрмийг шинэчлэн бүртгүүлэхээр 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл ирүүлсэн боловч тодорхой алдаа, зөрчлийн улмаас бүртгээгүй байна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэх боломжийг олгосны дагуу тус нам нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ баталсан байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Бүгд найрамдах намын шинэчилсэн дүрмийг бүртгэхээр шийдвэрлэв.

Нэг. Намын удирдах дээд байгууллага болох Их хурлыг зарлан хуралдуулсан талаар:

1.1.Бүгд найрамдах намын дүрэм (2019 он)-ийн 16.1-д “Намын Их хурал ээлжит ба ээлжит бус байна”, 16.3-т “Намын Бага хурлын нийт гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулж болно”, 16.5-д “Хуралд оролцвол зохих нийт төлөөлөгчдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ...”, 17.2-т “Бага хурал ээлжит ба ээлжит бус байна”, 17.2.2-т “Ээлжит бус хурлыг Бага хурлын нийт гишүүдийн гуравны нэгээс дээш хэсгийн шаардсанаар хэдийд ч зарлан хуралдуулж болно”, 18-д “Бага хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ”, 18.1-д “Намын Их хурлын товыг тогтоох”, 18.2-т “Намын Их хуралд оролцох төлөөлөгчдийн тоог тогтоох” гэж тус тус заажээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаас үзвэл, тус намын ээлжит бус Их хурлын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 24/03-08 дугаар тогтоолоор батлагдсан 101 гишүүний гуравны нэгээс дээш буюу 38 гишүүний саналаар 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Бага хурал хуралдсан, тус хуралд 101 төлөөлөгчөөс 68 төлөөлөгч оролцжээ.

Улмаар Бага хурлын 26/03-005 дугаар тогтоолын 1 дэх заалтаар Ээлжит бус Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хуралдуулахаар товлон зарлаж, 2 дахь заалтаар төлөөлөгчдийн тоог 70-75 байхаар тогтоосон, мөн өдрийн 26/03-006 дугаар тогтоолоор Ээлжит бус Их хурлын 103 төлөөлөгчдийн нэрсийг хавсралтаар баталж, хурлын товыг цахимаар буюу “Б.Жаргалсайхан Бүгд найрамдах нам” гэсэн фэйсбүүк хуудсаар дамжуулан намын гишүүдэд мэдэгдсэн бөгөөд хуралд 103 төлөөлөгч оролцохоос олонх буюу 73 төлөөлөгч оролцсон болох нь өргөдөлд хавсарган ирүүлсэн ирцийн бүртгэл, хурлын тэмдэглэл, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтуудаар тогтоогдож байна. Иймд Ээлжит бус Их хурлыг намын дүрэмд заасны дагуу зарлан хуралдуулсан байна.

Тухайн намаас “төлөөлөгчдийн нийт тоо 103 байх бөгөөд үүнээс 70-75 оролцсон тохиолдолд хурлыг хүчин төгөлдөрт тооцохоор баталсан” гэсэн тайлбарыг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр шүүхэд ирүүлснийг дурдав.

Хоёр. Намын шинэчилсэн дүрмийг баталсан талаар:

2.1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж;

Бүгд найрамдах намын дүрэм (2019 он)-ийн 16.4-т “Их хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:”, 16.4.1-д “Намын мөрийн хөтөлбөр, дүрмийг шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах”, 16.5-д “... хуралд

оролцогсдын ердийн олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно” гэж тус тус заажээ.

Бүгд найрамдах намын Ээлжит бус Их хурал 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж, намын дүрмийг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэх асуудлыг хэлэлцэж, хуралд оролцсон 73 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжсэн болох нь Тооллогын комиссын 26/03-03-2 дугаар тогтоол, Ээлжит бус Их хурлын 26/03-05 дугаар тогтоол, хуралдааны тэмдэглэл, дүрс бичлэг болон бусад бичгийн баримтуудаар тогтоогдож байна.

2.2. Тус намын IX Их хурлын 2025 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 25/12-04 дүгээр тогтоолоор баталсан дүрмийг Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02/336 дугаар албан бичгээр “... намын дүрэмд зайлшгүй тусгах шаардлагатай зүйлийг орхигдуулсан, хуульд заасан асуудлыг дүрэмд өөрөөр зохицуулсан нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцээгүй” гэсэн үндэслэлээр болон бусад алдаа зөрчлийг дурдаж буцаасан.

Намын шинэчилсэн дүрэм нь Намын зорилго, үзэл баримтлал, үнэт зүйл, Намын бэлгэдэл, Намын гишүүн, дэмжигч, түүний эрх, үүрэг, хариуцлагын төрөл, Намын бүтцийн байгууллага, Намын удирдлага, Намын санхүүжилт, Намын санхүүгийн үйл ажиллагаа, тайлан, хяналт, Намын үйл ажиллагаа дуусгавар болох, намын дүрмийг дагаж мөрдөх гэсэн нийт 8 бүлгээс бүрдсэн байх бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-15.2.10-т заасан намын дүрэмд тавигдах шаардлагад нийцжээ.

Тухайлбал, Бүгд найрамдах намын Ээлжит бус Их хурлын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар өмнөх албан бичигт дурдсан “намын дүрэмд сахилгын шийтгэл оногдуулах хөөн хэлэлцэх хугацаа, намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөн, намын дүрмийг санаатай зөрчсөн гэж үзэх үйлдэл, эс үйлдэхгүйг тодорхойлж заагаагүй, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтныг томилохоор намын дүрмийн 19.6.14-т зохицуулсан нь хуульд нийцээгүй, Улс төрийн зөвлөлийн гишүүдийг чөлөөлөгдөх, огцрох үндэслэл тодорхойгүй, хаанаас хэрхэн нөхөн сонгохыг зохицуулаагүй, намын хорооны даргын чөлөөлөх зохицуулалт нь тодорхойгүй, намд олгох жил бүрийн төрийн санхүүжилтийн хувийг ямар зориулалтаар зарцуулах, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг хуваарилах, хуваарилахгүй байх шалгуур, нөхцөл, хувь хэмжээ, шийдвэр гаргах эрх хэмжээг намын дүрэмд тусгаагүй” зэрэг алдаа, зөрчлүүдийг дараах байдлаар зассан байна. Үүнд:

Намын шинэчилсэн дүрмийн:

-8.1.1-д “Намын гишүүн намын үзэл баримтлал, үнэт зүйлийн эсрэг үйл ажиллагаа явуулсан, аливаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг дэмжсэн, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол, намын үнэт зүйлс, зарчмыг ноцтой зөрчсөн, намын нэр хүнд, эв нэгдэлд хохирол учруулсан, улс төрийн сонгуульд нам болон нэр дэвшигчийн эсрэг үйл ажиллагаа явуулсан, намын хөрөнгө, санхүүд хохирол учруулсан бол намын дүрмийг санаатай зөрчсөн гэж тооцогдох бөгөөд Хяналтын зөвлөлийн шийдвэрээр намын гишүүнээс хасна” гэж;

-8.1.4-т “Намын сонгуульт гишүүний гаргасан сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 30 хоногийн дотор сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд 30 хоног өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй” гэж,

-14.6-д “Намын хорооны дарга, тэргүүлэгч гишүүнийг намаас гарсан, намын гишүүнээс түдгэлзвэл зохих төрийн албан тушаалд сонгогдсон, томилогдсон, намын хорооны тэргүүлэгч гишүүнээс чөлөөлөгдөх өргөдөл гаргасан, өөр аймаг, дүүрэг рүү шилжин явсан, эрүүл мэндийн шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд нөхөн сонгох сонгуулийг Намын хорооны тэргүүлэгчид 30 хоногийн дотор зохион байгуулна ...”;

-19.1-д “... Улс төрийн зөвлөлийн гишүүн намаас гарсан, төрийн албан тушаалд сонгогдсон, томилогдсон, Улс төрийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх өргөдөл гаргасан, эрүүл мэндийн шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх, өөрчлөгдөх тохиолдолд Хяналтын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Улс төрийн зөвлөлөөс санал болгосон 2 хүний нэрийг дэвшүүлж, 45 хоногийн дотор нууц санал хураалт явуулж, олонхын саналаар нөхөн сонгоно”;

-19.7-д “Улс төрийн зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:”, 19.7.14-т “Намын Ерөнхий нарийн бичгийн даргаас намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтанд нэр дэвшүүлсэн 2-оос доошгүй нэр дэвшигчийг хэлэлцэн, нууц санал хураалтаар олонхын санал авсан нэр дэвшигчийг сонгож батална”;

-26.6-д “Эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэхэд 20-оос доошгүй хувийг, намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулахад 15-аас доошгүй хувийг, намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэхэд 15-аас доошгүй хувийг, Намын салбар болон бүтцийн нэгж бүр 50 хүртэл хувийг зарцуулна. Намын зорилтот дээрх санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын бодлогын судалгааны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулна.”

-26.7-д “Төрийн санхүүжилтийг Намын салбар болон бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд 50 хүртэл хувийг хуваарилна” гэж тус тус заажээ.

2.3.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Намын гишүүнээс хасах асуудлыг тогтоосон журмын дагуу намын хяналтын байгууллага шийдвэрлэнэ” гэж заасан.

Гэтэл тус намын шинэчилсэн дүрмийн 8.1.1-д “Намын гишүүн ... намын үнэт зүйлс, зарчмыг ноцтой зөрчсөн, намын нэр хүнд, эв нэгдэлд хохирол учруулсан, ... бол намын дүрмийг санаатай зөрчсөн гэж тооцогдох бөгөөд Хяналтын зөвлөлийн шийдвэрээр намын гишүүнээс хасна”, 17 дугаар зүйлд “Бага хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ” гээд 17.4-т “Хяналтын зөвлөлийн санал болгосноор намын гишүүнээс хасах асуудлыг шийдвэрлэх” гэж зааснаас үзэхэд намын гишүүнийг хаанаас хасах нь ойлгомжгүй байсныг тус намын 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 26/04-01 дугаартай албан бичгээр “... Хяналтын зөвлөлийн шийдвэрийг төлөөллийн төв байгууллагад танилцуулна, өөрөөр хэлбэл

хяналтын зөвлөл намын гишүүнээс хасах тухай мэдээллийг гишүүдэд өгөх ба Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 18.3-т “Намын хяналтын байгууллага хараат бусаар ажиллах бөгөөд түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэсэн заалтын дагуу хяналтын зөвлөлийн шийдвэр эцсийнх байна” гэсэн тайлбарыг ирүүлсэн байх тул энэ нь намын дүрмийг бүртгэхээс татгалзах ноцтой зөрчил биш гэж үзлээ.

Мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна” гэжээ.

Тус намаас төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг дүрмийн 26.6-д “... намын салбар болон бүтцийн нэгж бүр 50 хүртэл хувийг зарцуулна” гэж тусгасан атлаа дүрмийн 26.7-д “Төрийн санхүүжилтийг намын салбар болон бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд 40 хүртэл хувийг хуваарилна” гэж зөрүүтэй заасан, үүнийг “намын дүрэмд техникийн алдаа гарч бичигдээгүй орхигдсон байна” гэж тайлбарласан байх тул уг алдааг засуулах боломжтой гэж дүгнэв.

Иймд, Бүгд найрамдах намын шинэчилсэн дүрэм нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, бүртгэхээс татгалзах ноцтой зөрчил байхгүй тул бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсэгт заасныг баримтлан Бүгд найрамдах нам (БНН)-ын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ